ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/281 Арвайхээр

# Аян зохион байгуулах тухай

Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, орон сууцны улсын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд хүн ам, өрхийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах, мэдээллийн сангийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор “Хүн ам, өрхийн бүртгэл мэдээллийг сайжруулах” сарын аяныг 2019 оны 5 дугаар сарын 1-нээс 31-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сарын аяны хугацаанд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, аяны удирдамжийг хоёрдугаар, аймгийн тооллогын комисс, түр товчоодын гишүүдийн сумдад ажиллах хуваарийг гуравдугаар, аяны арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлалсугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу аяныг үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг 6 дугаар сарын 20-ны дотор аймгийн Статистикийн хэлтэст ирүүлэхийг сумдын тооллогын комиссын дарга Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Аяны арга хэмжээнд шаардагдах 5,800.000 (таван сая найман зуун мянга) төгрөгийг Үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Г. ГАНБОЛД

011100649

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугээр сарын 01-ны өдрийн А/81 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

“ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГО-2020”, “БАЙШИН, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГО-2019”-ИЙГ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД **“ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ”** САРЫН АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Хүрэх үр дүн | Хариуцан гүйцэтгэх байгууллага |
|---|---|---|---|---|
| | ***ХАӨМС-ийн бүртгэл, мэдээллийг баяжуулах, сайжруулах*** | | | |
| 1 | Өрхийн бүртгэлийн дэвтрийг сум, багийн өрх, хүн ам нэг бүрээр шинэчлэн хөтөлж, ХАӨМСанг баяжуулах | 5 дугаар сард | Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр сум, багийн нийт өрх, хүн амаар 100 хувь шинэчлэн хөтлөгдсөн байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 2 | Аймгийн тооллогын комисс, түр товчооны гишүүд хуваарилагдсан сум, багт очиж ажиллан хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлт, ХАӨМСангийн баяжилтанд хяналт тавих, зөвлөн туслах | 5 дугаар сард | Аймгийн тооллогын комисс, түр товчооны гишүүд удирдамж чиглэлийн дагуу хариуцсан сум, багтаа очиж ажилласан байна. | Аймгийн тооллогын комисс, Статистикийн хэлтэс |
| 3 | Сум багийн нийт хүн амын өрхийн тэргүүлэгчийн хамаарал, үндэс угсаа, суурьшлын байдал, оршин суугаа бүртгэлийг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр шинэчлэн гаргаж, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум багийн нийт хүн амын өрхийн тэргүүлэгчийн хамаарал, үндэс угсаа, суурьшлын байдал, оршин суугаа бүртгэлийг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн шинэчлэн гаргасан байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 4 | Сум багийн нийт хүн амын гэрлэлтийн байдлыг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр шинэчлэн гаргаж, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум багийн нийт хүн амын гэрлэлтийн байдлыг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн шинэчлэн гаргасан байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 5 | Сум, багийн ХАӨМСанд бүртгэлтэй нийт хүн амын боловсрол, СӨБ, ЕБС-д хамрагдалтын байдал, эзэмшсэн мэргэжлийг хүн нэг бүрээр тодруулан, судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр гаргаж, ХАӨМСанд байршуулах | 5 дугаар сард | Сум, багийн ХАӨМСанд бүртгэлтэй нийт хүн амын боловсрол, СӨБ, ЕБС-д хамрагдалтын байдал, эзэмшсэн мэргэжлийг хүн нэг бүрээр тодруулан, судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн гаргаж дууссан байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 6 | Сум, багийн ХАӨМСанд бүртгэлтэй нийт хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилладаг байгууллага, эрхэлдэг | 5 дугаар сард | Сум, багийн ХАӨМСанд бүртгэлтэй нийт хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилладаг | Сум, багийн тооллогын комисс, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажил, үйл ажиллагааны чиглэлийн судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр судалгааг гаргаж, ХАӨМСанд байршуулах | | байгууллага, эрхэлдэг ажил, үйл ажиллагааны чиглэлийн судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн гаргаж дууссан байна. | түр товчоо |
| 7 | Сум, багийн ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхэлдэггүй шалтгааныг хүн нэг бүрээр хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр шинэчлэн авч, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум, багийн ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхэлдэггүй шалтгааныг хүн нэг бүрээр хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн шинэчлэн авч дууссан байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 8 | Сум, багийн нийт хүн амын орлогын хэлбэрийг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр шинэчлэн авч, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум, багийн нийт хүн амын орлогын хэлбэрийг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн шинэчлэн авч дууссан байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 9 | Сум, багийн хүн амын хөгжлийн бэрхшээл, халамжид хамрагдалтын байдлыг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр шинэчлэн гаргаж, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум, багийн хүн амын хөгжлийн бэрхшээл, халамжид хамрагдалтын байдлыг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн шинэчлэн гаргаж, аймгийн халамжийн сантай тулгалт хийсэн байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 10 | Сум багийн 18-аас дээш насны эрчүүдийн цэргийн алба хаасан эсэх судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр шинэчлэн гаргаж, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум багийн 18-аас дээш насны эрчүүдийн цэргийн алба хаасан эсэх судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн шинэчлэн гаргаж, аймгийн цэргийн штабын мэдээллийн сантай тулгалт хийсэн байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 11 | Сум багийн нийт өрхийн тээврийн хэрэгсэлтэй эсэх судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр шинэчлэн гаргаж, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум багийн нийт өрхийн тээврийн хэрэгсэлтэй эсэх судалгааг хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр бүрэн шинэчлэн гаргаж, аймгийн тээврийн сан, татварын мэдээллийн сантай тулгасан байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 12 | Сум, багийн нийт өрхийн сууцны төрөл, эзэмшлийн болон өмчлөлийн хэлбэрийг өрхийн дэвтрээр бүрэн шинэчилж, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум, багийн нийт өрхийн сууцны төрөл, эзэмшлийн болон өмчлөлийн хэлбэрийг өрхийн дэвтрээр бүрэн шинэчилж дууссан байна. | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| 13 | Сум, багийн нийт өрхийн цахилгааны эх үүсвэр, усан хангамж, бохир ус зайлуулалт, хатуу хог хаягдал зайлуулалт, бие засах газрын төрлийг хүн ам, өрхийн дэвтрээр бүрэн шинэчилж, ХАӨМСанд шивэх | 5 дугаар сард | Сум, багийн нийт өрхийн цахилгааны эх үүсвэр, усан хангамж, бохир ус зайлуулалт, хатуу хог хаягдал зайлуулалт, бие засах газрын төрлийг хүн ам, өрхийн дэвтрээр бүрэн шинэчилж | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дуусcан байна. | |
| 14 | Сум, багийн нийт өрхийн хаягийг зөв тодруулан, ХАӨМСанд оруулах | 5 дугаар сард | Сум, багийн нийт өрхийн хаягийг зөв тодруулан, газрын хаягийн мэдээллийн сантай тулгасан байна. | |
| 15 | Харьяа нутаг дэвсгэрийн өрхийн хаягийн мэдээлэл, гудамж, зам, талбайн нэр, орон, сууц хашаа, байрны хаягжилт, дугаарлалтыг цэгцэлж, хаягжуулах ажлыг зохион байгуулах | 5 дугаар сард | Харьяа нутаг дэвсгэрийн өрхийн хаягийн мэдээлэл, гудамж, зам, талбайн нэр, орон, сууц хашаа, байрны хаягжилт, дугаарлалтыг цэгцэлж, хаягжуулах ажлыг зохион байгуулах | Сум, багийн тооллогын комисс, түр товчоо |
| **Хяналт, үнэлгээ** | | | | |
| 16 | "Хүн ам, өрхийн мэдээллийг шинэчлэн баяжуулах, ХАӨМСангийн чанар, үр дүнг сайжруулах" сарын аяныг сум, багийн түвшинд зохион байгуулсан байдал, төлөвлөлт, хяналт, сум, багийн тооллогын комисс, түр товчоодын ажлыг шалгаж, зөвлөн туслах | 5-6 дугаар сард | Аймгийн тооллогын комисс, түр товчооний гишүүд сум багт очиж ажиллахаас гадна шаардлагатай сум, багийн Засаг даргыг аймагт дуудан ирүүлж тухайн ажлыг шалгаж, зөвлөгөө өгсөн байна. | Аймгийн тооллогын комисс, түр товчоо |
| 17 | Сум багийн нийт өрх, хүн амын мэдээллийг бүртгэлийн дэвтрээр бүх өрх, хүн амаас авсан эсэх, чанар үр дүнг нягтлан шалгах | 5-6 дугаар сард | Сум багийн нийт өрх, хүн амын мэдээллийг бүртгэлийн дэвтрээр бүх өрх, хүн амаас авсан эсэхийг бүртгэлийн дэвтрийг хүн амын тоотой тулган шалгаж, зөвлөгөө өгсөн байна. | Аймгийн тооллогын комисс, түр товчоо |
| 18 | Бүртгэлийн дэвтрээр шинэчилж авсан өрх, хүн амын мэдээллийг ХАӨМСанд шивэх ажлын зохион байгуулалт, чанар үр дүнг шалгах, явцын хяналт тавих | 5-6 дугаар сард | Бүртгэлийн дэвтрээр шинэчилж авсан өрх, хүн амын мэдээллийг ХАӨМСанд шивэх ажлын зохион байгуулалт, чанар үр дүн сайжирсан байна. | Аймгийн тооллогын комисс, түр товчоо |

-oOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дүгээр сарын 01-ны өдрийн А/281 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

“ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ”
САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

## НЭГ. ЗОРИЛГО

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын хүрээнд ХАӨМС-ын чанарыг сайжруулах, мэдээллийг баяжуулах, Аймгийн тооллогын комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хүн ам, өрхийн мэдээллийг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх

## ХОЁР. ХУГАЦАА

2019 оны 05 дугаар сарын 01-нээс 2019 оны 05 дугаар сарын 31-ний хооронд

## ГУРАВ. ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЙГУУЛЛАГА

Аймгийн тооллогын комисс, түр товчоо
Аймаг, сумын ЗДТГ, Статистикийн хэлтэс

## ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Сум, багийн Засаг дарга нар, сум, багийн тооллогын комисс, түр товчооны гишүүд

## ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- Сум, багийн хүн ам, орон сууцны тооллогын комисс, түр товчоогоор хуралдан, хүн ам, өрхийн бүртгэлийн шинэчилсэн дэвтрээр өрх тус бүрээр мэдээлэл шинэчлэх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах
- Өрхийн дэвтрээр шинэчилсэн мэдээллээ программд засах, шинээр оруулах ажлыг хариуцлагатай хийж, гүйцэтгэх

## ЗУРГАА. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

- Сум багийн нийт өрх, хүн амын мэдээллийг бүртгэлийн дэвтрээр бүх өрх, хүн амаас авсан эсэх, чанар үр дүнг нягтлан шалгах
- Бүртгэлийн дэвтрээр шинэчилж авсан өрх, хүн амын мэдээллийг ХАӨМСанд шивэх ажлын зохион байгуулалт, чанар үр дүнг шалгах, явцын хяналт тавих
- Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр өрх, хүн амын мэдээллээ хэрхэн шинэчилж байгаа талаар сар тутам тайлан ирүүлэх

## ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН

Сарын хугацаанд хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрээр өрх, хүн амын мэдээллийн бүрэн авч, ХАӨМСанд оруулах ажил хийгдэж, нийт өрх, хүн амын үзүүлэлт бүрэн, зөв болж, чанар тодорхой хувиар сайжирсан байна.

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дүгээр сарын 01-ны өдрийн А/281 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД АЙМГИЙН ТООЛЛОГЫН КОМИСС, ТҮР ТОВЧООНЫ ГИШҮҮДИЙН ХАРИУЦАЖ АЖИЛЛАХ СУМДЫН ХУВААРЬ

| Д/Д | Овог нэр | Албан тушаал | Хариуцаж ажиллах сум |
|---|---|---|---|
| **Хүн ам, орон сууцны аймгийн тооллогын комисс** | | | |
| 1 | И.Доржсүрэн<br>Д.Шиваанүрдэв<br>Х.Мөнхцэцэг | Аймгийн Засаг даргын орлогч<br>ЭМГазрын дарга<br>Статистикийн хэлтсийн мэргэжилтэн | Хужирт, Хархорин |
| 2 | Т.Гончигдорж<br>М.Дэлгэрсайхан<br>С.Зоригтбаатар<br>Н.Даваатогтох | ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга<br>Аймгийн ЗДТГазрын Цэргийн штабын дарга<br>ГХБХБГазрын мэргэжилтэн<br>Статистикийн хэлтсийн судлаач | Төгрөг, Гучин-Ус |
| 3 | Ц.Ганболд<br>Д.Эрдэнэбат<br>Ч.Гүнсэнхорол<br>Г.Энхцэцэг | Аймгийн ЗДТГазрын дарга<br>ОБГазрын дарга<br>ГХБХБГазрын дарга<br>Статистикийн хэлтсийн мэргэжилтэн | Есөнзүйл, Өлзийт |
| 4 | Д.Нэмэхбаяр<br>О.Түмэнжаргал<br>П.Мөнхзул | Аймгийн ЗДТГазрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга<br>Статистикийн хэлтсийн дарга<br>Аймгийн ЗДТГазрын ТЗУ-ын хэлтсийн мэргэжилтэн | Нарийнтээл, Хайрхандулаан |
| 5 | Г.Баясгалан<br>Б.Сайнжаргал<br>Ц.Гаваа | Аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга<br>Аймгийн ЗДТГазрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга<br>Статистикийн хэлтсийн судлаач | Богд, Баруунбаян-Улаан |
| 6 | С.Ундрах<br>Д.Оюунсүрэн<br>Б.Бүзмаа<br>Д.Чанцалдулам | ХХҮГазрын дарга<br>УБХ-ийн Тасгийн дарга<br>Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн<br>Статистикийн хэлтсийн зохион байгуулагч | Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий |
| 7 | А.Отгонцэцэг<br>Р.Уранчимэг<br>Э.Өүлэн | Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга<br>ЭМГ-ын статистик хариуцсан мэргэжилтэн<br>Статистикийн хэлтсийн мэргэжилтэн | Уянга, Тарагт |
| 8 | А.Мөнхтөр<br>Д.Эрдэнэбат<br>Д.Отгоннасан | УБХэлтсийн дарга<br>ОБГ-ын дарга<br>Статистикийн хэлтсийн судлаач | Баянгол, Сант |
| 9 | Т.Ариунболд<br>Ж.Пүрэвсүрэн<br>Д.Чулуунцэцэг | БОАЖГазрын дарга<br>БСУГазрын дарга<br>Статистикийн хэлтсийн мэргэжилтэн | Баян-Өндөр, Бүрд |
| 10 | О.Пүрэвдорж<br>З.Балданням<br>Х.Мөнхцэцэг<br>Э.Өүлэн | Арвайхээр сумын Засаг дарга<br>Авто тээврийн газрын дарга<br>Статистикийн хэлтсийн мэргэжилтэн | Арвайхээр |

-oOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дүгээр сарын 01-ны өдрийн А/281 дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

# ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ” САРЫН АЯНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/Д | Зардлын төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ /мян,төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тооллогын комисс, түр товчооны гишүүд сумдад ажиллах шатахууны зардал | л | 1396 | 1790 | 2500.0 |
| 2 | Гэрээт ажилтны цалин | - | 1 хүн /6 сар/ | 550000 | 3300.0 |
| Нийт дүн | | | | | 5800.0 |

-oOo-